

	БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ ШУТИС-СҮ-ЖУ11	Эхний хэвлэлт Өөрчилсөн огноо Өөрчлөлтийн дугаар	1991.05.01 2021.04.20 31
--	---	--	--------------------------------

БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

(2021-2022 оны хичээлийн жил)

Боловсруулсан:

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, БҮРТГЭЛИЙН АЛБА

Хянасан:

СУРГАЛТ, ОЮУТНЫ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ


Баталсан:

ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ



АГУУЛГА

АГУУЛГА	3
Нэг. Нийтлэг үндэслэл.....	4
ХОЁР. Хамрах хүрээ	4
ГУРАВ. Норматив эш таталт.....	4
ДӨРӨВ. Нэр томьёоны тодорхойлолт.....	4
ТАВ. эрх мэдэл, үүрэг хариуцлага.....	5
ЗҮРГАА. элсэлтийн бүртгэл, баталгаажуулалт	6
6.1 Элсэгчдэд тавигдах шаардлага	6
6.2 Элсэлтийн бүртгэл.....	8
6.3 Ур чадварын шалгалт.....	8
6.4 Эрэмбэлэлт, онооны жагсаалт	8
долоо. Мэргэжил сонголт	8
7.1 Өдрийн анги	8
7.2 Шууд элсэлт, цагийн /эчнээ гараг, орой/ элсэлт	9
найм. суралцах гэрээ	10
8.1 Шинээр элсэгчийн бүртгэл	10
8.2 ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ	10
хавсралт 1. Үйл явцын зураглал.....	11
хавсралт 2. МЭРГЭЖИЛ	13
хавсралт 3. МЭРГЭЖИЛ	17



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль /ШУТИС/-д элсэн суралцааар хүсэлт гаргагч, элсэлтийн ажлыг удирдан зохион байгуулах Элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох стандартад нийцүүлэн сургуулийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтаан ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт намар, хаврын улиралд тус тус суралцагч элсүүлнэ.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ


ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх, бүртгэх, баталгаажуулах, ур чадварын шалгалт авах, мэргэжил сонголт хийлгэх үйл явцыг зохицуулна.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ

- 3.1 Дээд боловсролын тухай хуулийн 7-р зүйлийн 7.3 дахь заалт
- 3.2 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/79 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”
- 3.3 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- 3.4 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/195 тоот “Босго оноо тогтоох тухай” тушаал
- 3.5 Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/195 тоот “Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай” тушаал
- 3.6 ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- 3.7 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн нь БСШУ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, БСШУС-ын сайдын 2018 оны А/195 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалын 4.1.7 дахь заалт

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид ЭЕШ/:** Дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх хүсэлтэй бүрэн дунд боловсролтой иргэн монгол хэл, бичиг, ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий шалгалтыг хэлнэ.
- 4.2 **Суралцагч элсүүлэх бүлэг:** Хөтөлбөр, мэргэжлийг салбар, шинжлэх ухааны чиглэлээр бүлэг болгож хуваах ба ШУТИС-ийн хөтөлбөрүүдийг 5 үндсэн бүлэгт хуваана. Үүнд:
 - 1-р бүлэг – Инженер, технологийн мэргэжлүүд
 - 2-р бүлэг – Бизнесийн удирдлага, менежментийн мэргэжлүүд
 - 3-р бүлэг – Архитектур, дизайны мэргэжлүүд



4-р бүлэг – Нийгэм, хүмүүнлэгийн ухааны мэргэжлүүд


5-р бүлэг – Гадаад хэлний орчуулгын мэргэжлүүд

- 4.3 **Элсэлтийн бүртгэл:** Элсэлтийн веб хуудсанд нэвтэрч хувийн мэдээллийг оруулж, элсэх хүсэлтэй хөтөлбөр мэргэжлийн бүлэг сонгож, цахимаар төлбөр төлж баталгаажуулах үйл явцыг элсэлтийн бүртгэл гэж үзнэ.
- 4.4 **Хөтөлбөр баталгаажуулалт:** Үндэсний босго онооны болзол хангаж хөтөлбөр, мэргэжлийн бүлэгт тохирох хичээлүүдээр ЭЕШ өгсөн элсэгч онооны жагсаалтын дагуу мэргэжил сонгон, баталгаажуулах үйл явцыг хэлнэ.
- 4.5 **Хяналтын тоо:** Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс баталсан хөтөлбөр, мэргэжилд элсүүлэх суралцагчийн тоо
- 4.6 **Товчилсон үгсийн тайлбар:**

№	Сургуулийн нэр	
1	Барилга, архитектурын сургууль	БАС
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	БУХС
3	Геологи, уул уурхайн сургууль	ГУУС
4	Механик, тээврийн сургууль	MexTC
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	MХТС
6	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ҮТС
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХШУС
8	Эрчим хүчний сургууль	ЭХС
9	Гадаад хэлний сургууль	ГХС
10	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	ДарТС
11	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	ЭрЦДС

ТАВ. ЭРХ МЭДЭЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1 ШУТИС-ийн Захирал
- Элсэлтийн төв комисс, салбар комисс тус бүрийг тушаалаар байгуулна.
 - Элсэлтийн комиссын бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарийн тушаал гаргана.
 - Элсэгчдийн үйл ажиллагааны мэдээ тайлантай танилцана.
- 5.2 Элсэлтийн төв комисс
- Элсэлтийн бэлтгэл ажлыг хангана.
 - Ур чадварын шалгалтыг зохион байгуулна.
 - Элсэлтийн үеийн өргөдөл гомдлыг хүлээн авч, барагдуулна.
 - Элсэлтийн явцад хяналт тавих болон элсэлттэй холбоотой бусад үйл ажиллагааг зохицуулна.
 - Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг хянана.




- 5.3 Сургалтын хөтөлбөр, бүртгэлийн алба
 - Тус журмыг боловсруулж, батлуулна.
 - Элсэлтийн төв комисс, салбар комиссийн бүрэлдэхүүний саналыг боловсруулна.
 - Элсэлтийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж ажиллана.
 - Элсэлтийн салбар комиссыг удирдлагаар хангаж ажиллана.
 - Элсэгчдэд зориулсан цахим гарын авлагыг боловсруулж, мэдээлнэ.
 - Шинээр элсэгчийн хувийн бичиг баримтыг хүлээн авч, гэрээнд заасан хугацаагаар хадгална.
- 5.4 Мэдээллийн технологийн төв
 - Цахим элсэлтийн програм хангамжийг хөгжүүлнэ.
 - Цахим элсэлтийн програм хангамжийн найдвартай, хэвийн ажиллагааг хангана.
 - Сервер, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангана.
- 5.5 Маркетинг, олон нийттэй харилцах алба
 - Элсэлтийн маркетинг хийнэ.
 - Элсэлтийн үйл ажиллагааг олон нийтэд цаг тухай бүрт мэдээлнэ.
 - Хөтөлбөр, мэргэжлийн танилцуулгыг цахимаар олон нийтэд хүргэнэ.
 - Элсэлтийн маркетингийн үйл ажиллагааг тайлagnana.
- 5.6 Эрүүл мэнд, спортын төв
 - Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулна.
 - Элсэг бүрт эрүүл мэндийн үзлэгийн цахим бүртгэлийн хуудас үүсгэнэ.
- 5.7 Бүрэлдэхүүн сургууль
 - Хөтөлбөр, мэргэжлийн цахим болон хэвлэмэл танилцуулга, гарын авлага боловсруулна.
 - Хөтөлбөр, мэргэжлийг танилцуулах, сурталчилан, мэдээлнэ.
 - Шинээр элсэгчтэй суралцах гэрээ байгуулна.
- 5.8 Элсэхийг хүсэгч /шинэ элсэгч/
 - Элсэлтийн веб хуудсанд өөрийн мэдээллийг үнэн зөв оруулна.
 - Цахим элсэлтийн бүртгэлийг баталгаажуулж төлбөр төлнө.
 - Босго онооны болзолыг хангасан бол суралцагч элсүүлэх бүх бүлэгт бүртгүүлж болно.
 - Хөтөлбөр, мэргэжил сонголт хийнэ.
 - Бүрдүүлэх бичиг баримтыг шаардлагын дагуу бүрдүүлж, хүлээлгэн өгнө.
 - Элсэлтийн журам, элсэгчдэд зориулсан гарын авлагатай танилцана.
 - Сонгосон сургуультай суралцах гэрээг байгуулна.

ЗУРГАА. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ

6.1 Элсэгчдэд тавигдах шаардлага

- 6.1.1 Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь бүрэн дунд боловсролтой иргэн байна.
- 6.1.2 ШУТИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч бүлэгт заасан хичээлээр Элсэлтийн ерөнхий шалгалт /ЭЕШ/ өгч БШУЯ-аас баталсан үндэсний босго онооны болзлыг хангасан байна.



6.1.3 Суралцагч элсүүлэх бүлэг, харгалзах ЭЕШ хичээл, босго оноо

Улаанбаатар хотод харьяалагдах бүрэлдэхүүн сургуулийн хувьд:

Бүлэг	Салбар чиглэлийн хөтөлбөр	Ерөнхий шалгалтын оноог тооцох хичээлүүд		Босго оноо
		Суурь хичээл 70%	Дагалдан хичээл 30%	
1	Инженер технологи чиглэлийн мэргэжил	Математик, Физик, Хими, Гадаад хэл	<ul style="list-style-type: none"> Математик Физик Хими Нийгмийн тухай мэдлэг Газарзүй Монголын түүх Гадаад хэл Монгол хэл Биологи 	Суурь хичээл 480, Дагалдан хичээл 480
2	Бизнесийн удирдлага, менежментийн чиглэлийн мэргэжил	Математик, Гадаад хэл	<ul style="list-style-type: none"> Математик Физик Хими Нийгмийн тухай мэдлэг Газарзүй Монголын түүх Гадаад хэл Монгол хэл Биологи 	Суурь, дагалдан хичээлүүдээс тус бүр нэг хичээлийн оноог босго оноонд тооцно.
3	Дизайн, арт чиглэлийн мэргэжил	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> Математик Физик Гадаад хэл 	Суурь хичээл 480, Дагалдан хичээл 480 Суурь, дагалдан хичээлүүдээс тус бүр нэг хичээлийн оноог босго оноонд тооцно.
4	Нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлийн мэргэжил	Математик, Нийгмийн тухай мэдлэг	<ul style="list-style-type: none"> Математик Физик Хими Нийгмийн тухай мэдлэг Газарзүй Монголын түүх Гадаад хэл Монгол хэл Биологи 	Суурь хичээл 480, Дагалдан хичээл 480 оноо.
5	Гадаад хэлний чиглэлийн мэргэжил	Гадаад хэл, Монгол хэл, Математик	<ul style="list-style-type: none"> Газарзүй Монголын түүх Гадаад хэл Монгол хэл Биологи 	Суурь, дагалдан хичээлүүдээс тус бүр нэг хичээлийн оноог босго оноонд тооцно.

Жич: Хөдөө орон нутгийн сургуульд хичээл тус бүр 400 оноо байна.

6.1.4 ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцахыг хүссэн гадаадын иргэдийн асуудлыг холбогдох журмаар зохицуулна.

6.1.5 ШУТИС-ийн бүрэлдэхүүн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль, Орхон аймаг дахь Технологийн сургуулийн элсэлтийн журам, элсэлтийн босго оноо тусдаа зарлагдана. Эдгээрийн элсэлт авах хөтөлбөр, мэргэжлийг хавсралт 3-аас үзнэ үү.



6.2 Элсэлтийн бүртгэл

- 6.2.1 ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт орон даяар цахим элсэлтийн бүртгэлийг www.elselt.edu.mn- Элсэлтийн вэб хуудсаар дамжуулан хийнэ.
- Намрын улиралд элсэхийг хүсэгчдийг 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хооронд бүртгэнэ.
- 6.2.2 Элсэхийг хүсэгч нь элсэлтийн вэб хуудсанд нэвтрэхдээ Боловсролын үнэлгээний төвийн (БҮТ) системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтэрч, мэдээлийг үнэн зөв оруулан, бүртгэлийн хураамжийг цахимаар төлж баталгаажуулна.
- 6.2.3 Аймаг, орон нутгаас суралцагчийг элсүүлэх мэргэжил сонголт дээр зөвхөн уг аймагт оршин суугаа иргэд, Улаанбаатар хотоос элсүүлэх мэргэжил сонголт дээр зөвхөн Улаанбаатар хотод Ерөнхий боловсролын дунд сургууль төгссөн буюу байнга оршин суугч иргэд цахимаар бүртгүүлэх эрхтэй.
- 6.2.4 Элсэлтийн материалыг хуурамчаар бүрдүүлсэнтэй холбогдон гарах хариуцлагыг бүртгүүлэгч хүлээнэ.

6.3 Үр чадварын шалгалт

- 6.3.1 Суралцагч элсүүлэх бүлгийн 3-т хамарагдах мэргэжилд элсэхийг хүсэгчид үр чадварын шалгалт өгнө.
- 6.3.2 Үр чадварын шалгалтыг цахим хэлбэрээр орон даяар явуулах ба шалгалт авах огноо, удирдамжийг элсэлтийн төв комисс хэлэлцэн, батлаж мэдээллийн боломжит бүх сувгаар мэдээлнэ.


6.4 Эрэмбэлэлт, онооны жагсаалт

- 6.4.1 Элсэгчдийн онооны жагсаалтыг суурь ба дагалдан хичээлийн онооны нийлбэр (6.1.3 хүснэгт)-ээр эрэмбэлж, элсэлтийн веб хуудсанд байршуулна.
- 6.4.2 Элсэлтийн бүртгэл хаасны дараа бүртгэлээ баталгаажуулсан элсэхийг хүсэгчдийн ЭЕШ-ийн оноог БҮТ-ийн серверээс татаж, босго оноотой харьцуулан эрэмбэлнэ.
- 6.4.3 Суралцагч элсүүлэх бүлэг тус бүрээр элсэхийг хүсэгчдийн онооны жагсаалтыг бүртгэл хаасан өдөр элсэлтийн вэб хуудсаар дамжуулан мэдээлнэ.
- 6.4.4 Элсэхийг хүсэгчдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд эхлээд суурь хичээлийн авсан дүн, дараа нь дагалдан хичээлээр авсан дүнг харьцуулах бөгөөд шаардлагатай бол гүйцэтгэлийн хувийг харьцуулж боловсруулалт хийнэ.

ДОЛОО. МЭРГЭЖИЛ СОНГОЛТ

7.1 Өдрийн анги

- 7.1.1 Мэргэжил сонгох үйл ажиллагааг орон даяар цахим хэлбэрээр www.elselt.edu.mn веб хуудсаар 2021 оны 08-р сарын 24-өөс 08-р сарын 27-ны хооронд хийнэ.
- 7.1.2 Мэргэжил сонгох үйл ажиллагааг элсэлтийн бүртгэл дууссан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан зохион байгуулна.



- 7.1.3 Мэргэжил сонгосон шинээр элсэгчид 2021 оны 08-р сарын 24-өөс 09-р сарын 05-ны хооронд элсэлтийн веб хуудсаар 2 кредитийн төлбөр төлж, хөтөлбөр баталгаажуулалт хийнэ.
- 7.1.4 6.1.3 хүснэгтэд заасан суралцагч элсүүлэх бүлгүүдийн аль нэгээс түрүүлж хяналтын тоог дуустал мэргэжил сонголтыг хийж, дараагийн бүлгийн мэргэжил сонголтыг үргэлжлүүлнэ.
- 7.1.5 ШУТИС-ийн хяналтын тоог баримтлан элсэхийг хүсэгчдийг онооны дарааллаар хавсралт 2-д заасан мэргэжлээс сонгуулж ШУТИС-д суралцах цахим эрхийн бичиг олгоно.
- 7.1.6 Онооны жагсаалтад багтсан элсэхийг хүсэгч дурьдсан хугацаанд мэргэжил сонгоогүй бол жагсаалтын дараагийн хүнээр хуваарь сонгуулна.
- 7.1.7 Мэргэжил сонголт хийж ШУТИС-д суралцах эрхийн бичиг авсан хүнд дахин өөр мэргэжил сонгохыг зөвшөөрөхгүй.
- 7.1.8 2021 онд ШУТИС-ийн Ахлах сургуулийг төгссөн төгсөгчдөөс бүрэн дунд боловсролын гэрчилгээний сурлагын дундаж үнэлгээ нь 83 ба түүнээс дээш, элсэлтийн ерөнхий шалгалтын оноо нь үндэсний босго оноог хангасан төгсөгчдийг онооны жагсаалтыг дагуу цахимаар мэргэжил сонгуулж ШУТИС-д элсүүлэн суралцуулна.
- 7.1.9 MCYT төгссөн төгсөгч нь ЭЕШ өгч ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тавигдах босго онооны болзол хангасан тохиолдолд элсэн суралцах боломжтой.
- 7.1.10 ШУТИС-ийн инженерийн бэлтгэл хөтөлбөрт Математик, физик, хими, нийгмийн тухай мэдлэг, гадаад хэлний хичээлийн аль нэгээр ЭЕШ өгсөн инженер технологийн чиглэлээр суралцах сонирхолтой иргэнийг элсүүлэн суралцуулна. Суралцагч 1 жилийн хугацаандаа элсэлтийн ерөнхий шалгалтанд орж үндэсний босго онооны болзол хангасан нөхцөлд сонгосон мэргэжлээрээ судалсан хичээлүүдийн кредитийг тооцуулан улмаар бакалаврын хөтөлбөрт дэвшин суралцах боломжтой.

7.2 Шууд элсэлт, цагийн /эчнээс гараг, орой/ элсэлт

- 7.2.1 Дээд боловсролтой иргэн ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт элсэж хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүсвэл “ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” –аар зохицуулагдана.
- 7.2.2 ШУТИС-ийн цагийн /эчнээ/ сургалтанд дээд боловсролтой болон техникийн боловсролтой иргэнийг элсүүлэн суралцуулна. Сургалтын бүртгэл 2021 оны 09 дугаар сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд явагдана.



НАЙМ. СУРАЛЦАХ ГЭРЭЭ

8.1 Шинээр элсэгчийн бүртгэл

- 8.1.1 Цахим суралцах эрхийн бичиг авсан элсэгчид www.elset.edu.mn веб хуудсанд нэвтэрч оюутны цахим анкет бөглөж 2021 оны 08 дугаар сарын 25 өдрөөс 09-р сарын 05-ны өдрүүдэд бичиг баримтын бүрдүүлэлт хийж Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албанад өөрийн биеээр ирж бүртгүүлнэ.
- 8.1.2 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын хичээл 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдөр эхлэнэ.
- 8.1.3 Шинээр элсэгчид эрүүл мэндийн үзлэгт орж оюутны эрүүл мэндийн хуудас нээлгэнэ.
- 8.1.4 Суралцах эрхийн бичиг авсан шинээр элсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - Суралцах гэрээг цахимаар бөглөн элсэлтийн веб хуудаснаас хэвлэнэ.
 - Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах бичиг баримт эх хувь, хуулбарын хамт
 - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ эх хувь хуулбарын хамт
 - Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хуудас эх хувь
 - ЕБС-ийн хувийн хэрэг эх хувь
 - Цээж зураг 3x4 хэмжээтэй 2 хувь мөн файл хэлбэрээр /сүүлийн 3 сард авхуулсан/
- 8.1.5 Суралцах эрхийн бичиг авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчдийг гэрээ байгуулахаас татгалзсан гэж үзэж элсэх эрхийг нь хүчингүй болсонд тооцно.

8.2 ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ ТЭТГЭЛЭГ

- 8.2.1 Элсэлтийн ерөнхий шалгалт өгч ШУТИС-ийн босго онооны болзол хангасан, авьяаслаг элсэгчдэд элссэн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах асуудлыг Элсэлтийн төв комисс шийдвэрлэнэ. Үүнд:
 - Олон улсын олимпиадын 1-3-р байр төлбөрийг 100 % хөнгөлнө.
 - 2020 оны техник-технологийн улсын олимпиадын 1-р байр эзэлсэн бол төлбөрийг 100% хөнгөлнө.
 - 2020 оны техник-технологийн улсын олимпиадын 2,3-р байр эзэлсэн бол төлбөрийг 75% хөнгөлнө.
 - 2020 оны техник-технологийн улсын олимпиадын 4,5-р байр эзэлсэн бол төлбөрийг 50% хөнгөлнө.
 - Мэргэжлийн улсын олимпиадын 1-5 дугаар байр эзэлсэн элсэгч төлбөрийг 50% хөнгөлнө.
 - ШУТИС-ийн харьяа ахлах сургууль төгссөн элсэгч ЭЕШ-нд хичээл тус бүр 650 ба түүнээс дээш оноо авсан бол төлбөрөөс 50-100% хөнгөлнө.
 - ЭЕШ-нд суурь болон дагалдан хичээл тус бүр 700-800 оноотой элсэгчийн төлбөрийг 50-100% хөнгөлнө.



ХАВСРАЛТ 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

Оролцооны тайлбар: [R] - Хариуцан хийж, гүйцэтгэх; [A] - Тухайн алхамд хариуцлага хүлээх, батлах; [C] - Тухайн алхмыг гүйцэтгэхдээ зөвлөлдөх, хамтрах оролцох; [I] – Алхмын гаралтын мэдээлэл авах

№	Оролт	Үйл явц	Гаралт	Оролцоо (RACI)						
				Э	СХБА	ЭТК	МТТ	ЭМСТ	БС	ШЗ
1	Элсэлтийн журам	Элсэлтийн төв комисс байгуулах	ШУТИС-ийн захирлын тушаал		R					A
2	ШУТИС-ийн захирлын тушаал	Элсэлтийн бэлтгэл ажлыг хангах	<ul style="list-style-type: none"> • Элсэгчдэд зориулсан гарын авлага • Элсэлтийн маркетинг, сурталчилгаа • Элсэлтийн вэб хуудас • Онлайн төлбөр, тооцоо 	I	C	R	C	C	C	
3	Элсэгчдэд тавигдах шаардлага	Элсэхийг хүсэгчдийг бүртгэх Ур чадварын шалгалт авах эсэх	<ul style="list-style-type: none"> • Бүртгэлийн хураамж • Элсэхийг хүсэгчдийн бүртгэл 	C	A	R	C		C	I
	Элсэхийг хүсэгчдийн бүртгэл	Шалгалт авах ажлыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> • Шалгалтын дүн 	C	A	R	C		C	
4	<ul style="list-style-type: none"> • Элсэхийг хүсэгчдийн бүртгэл • Шалгалтын дүн 	Эрэмбэлэлт хийх	<ul style="list-style-type: none"> • Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт 		A	R	C			
5	Бүртгүүлэгчдийн онооны жагсаалт	Онооны жагсаалтыг зарлах	Элсэлтийн вэб хуудас дахь мэдээлэл	I	A	R	C		I	I
6	Элсэлтийн вэбийн бүртгэл	Мэргэжил сонголт хийж, баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> • Шинэ оюутны бүртгэл • 2кр-ын төлбөр • Цахим суралцах эрхийн бичиг 	C	A	R	C		C	I



7	Цахим суралцах эрхийн бичиг	Эрүүл мэндийн үзлэгт оруулах	<ul style="list-style-type: none"> Цахим эрүүл мэндийн хуудас Үзлэгийн төлбөр 	C	C	C	R	
8	<ul style="list-style-type: none"> Шинэ оюутны бүрдүүлэх бичиг баримт Эрүүл мэндийн хуудас 	Сургалтын гэрээ байгуулах	<ul style="list-style-type: none"> Оюутны цахим анкет Сургалтын гэрээ Оюутны үнэмлэх 	R	C	C		A

**ХАВСРАЛТ 2. МЭРГЭЖИЛ**

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬД 2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН
ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ БАКАЛАВРЫН МЭРГЭЖИЛ**

№	Сургууль	№	Мэргэжил	Бүлэг
1	Барилга, архитектурын сургууль	1	Архитектур	3
		2	Халаалт, агаар сэлгэлт	1
		3	Усан хангамж, ус цэвэрлэгээ	1
		4	Хаягдал боловсруулах технологи	1
		5	Сантехникийн инженерийн байгууламж	1
		6	Иргэний ба үйлдвэрийн барилга	1
		7	Автозамын барилга	1
		8	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	1
		9	Усны барилга байгууламж	1
		10	Гүүрийн барилга	1
		11	Бетон, төмөр бетоны технологи	1
		12	Барилгын менежмент	2
		13	Усны нөөц экологи	1
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	14	Хүний нөөцийн менежмент	2
		15	Санхүүгийн менежмент	2
		16	Маркетингийн менежмент	2
		17	Мэдээллийн системийн менежмент	2
		18	Олон улсын бизнесийн менежмент	2
		19	Жижиг дунд үйлдвэрийн менежмент	2
		20	Харилцаа холбооны менежмент	2
		21	Хөнгөн үйлдвэрийн менежмент	2
		22	Төрийн удирдлага	4
		23	Аялал жуулчлалын менежмент	2
		24	Нийгмийн ажил	4
		25	Олон нийттэй харилцах ажил	4
		26	Байгууллагын сэтгэл судлал	4
		27	Бизнезийн удирдлага /БНСУ-тай хамтарсан/	4
3	Геологи уул, урхайн сургууль	28	Геодези	1
		29	Геодези /БНХАУ-тай хамтарсан/	1
		30	Геологи	1
		31	Ашигт малтмалын эрэл, хайгуул	1
		32	Геофизик	1
		33	Гидрогеологи	1
		34	Уул уурхайн ашиглалтын технологи	1



	35	Уул уурхайн ашиглалтын технологи /ХБНГУ-тай хамтарсан/	1
	36	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	1
	37	Өрөмдлөгийн техник, технологи	1
	38	Газрын тосны инженер	1
	39	Газар зохион байгуулалт	1
	40	Уул уурхайн маркшайдер	1
	41	Уул уурхайн менежмент	2
	42	Уул уурхайн машин тоног төхөөрөмж	1
	43	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	1
	44	Уул уурхайн геотехник	1
4	45	Машины электрон систем	1
	46	Механик системийн загварчлал	1
	47	Үйлдвэрлэлийн автоматжуулалт	1
	48	Үйлдвэрлэлийн механикуулалт	1
	49	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт	1
	50	Механик инженер	1
	51	Механик инженер /БНСҮ-тай хамтарсан/	1
	52	Механик инженер /HANBAT ИС-тай хамтарсан/	1
	53	Машин үйлдвэрлэлийн технологи	1
	54	Метал судлал, технологи	1
	55	Автомашины ашиглалт, авто аж ахуй	1
	56	Дотоод шаталтын хөдөлгүүр	1
	57	Нисэх техникийн механик	1
	58	Авионик	1
5	59	Логистик менежмент	2
	60	Төмөр замын тээврийн менежмент	2
	61	Тээврийн менежмент	2
	62	Зүтгүүр, вагоны инженер	1
	63	Гагнуурын технологи	1
	64	Механик инженер /БНСҮ-ын Сэүл их сургуултай хамтарсан/	1
	65	Мэдээллийн систем	1
	66	Мэдээллийн технологи	1
	67	Програм хангамж	1
	68	Цахилгаан холбоо	1
	69	Цахилгаан холбоо /ОХУ-тай хамтарсан/	1
	70	Утасгүй холбоо	1
	71	Утасгүй холбоо /ОХУ-тай хамтарсан/	1
	72	Сүлжээний технологи	1
	73	Мэдээллийн системийн аюулгүй байдал	1
	74	Системийн аюулгүй байдал /БНСҮ-тай хамтарсан/	1
	75	Автоматжуулалтын систем	1



	76	Электрон системийн програм хангамж	1
	77	Эмбеддэд систем	1
	78	Компьютерийн ухаан	1
	79	Мультимедиа дизайн	1
	80	Тоон медиа технологи	1
	81	Өгөгдлийн ухааны инженерчлэл	1
	82	Өгөгдлийн шинжилгээ	1
	83	Хиймэл оюун ухаан	1
	84	IoT технологи	1
	85	Робот ба хиймэл оюун ухаан	1
6	86	Хувцасны дизайн	3
	87	Компьютерийн график дизайн	3
	88	График дизайн	3
	89	Үйлдвэрлэлийн дизайн	3
	90	Интерьер дизайн	3
	91	Хүнс үйлдвэрлэлийн технологи	1
	92	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	1
	93	Хоол зүй, тэжээхүй ухаан	1
	94	Хүнсний чанар, аюулгүй байдал	1
	95	Мебель модон эдлэлийн технологи	1
	96	Ойн инженер	1
	97	Хэвлэлийн үйлдвэрлэлийн технологи	1
	98	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт	1
	99	Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи	1
	100	Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи	1
	101	Хүнсний биотехнологи	1
	102	Хүнсний микробиологи	1
	103	Хүнсний үйлдвэрийн менежмент	2
	104	Хөнгөн үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж	1
	105	Хүнсний үйлдвэрлэлийн машин аппарат	1
	106	Нэхмэлийн үйлдвэрлэлийн химийн технологи	1
	107	Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн химийн технологи	1
7	108	Химийн инженерчлэл	1
	109	Химийн инженерчилэл /БНХАУ-тай хамтарсан/	1
	110	Органик бус бодисын химийн технологи	1
	111	Нүүрсний боловсруулалтын технологи	1
	112	Газрын тосны боловсруулалтын технологи	1
	113	Үйлдвэрийн экологийн инженер	1
	114	Үйлдвэрийн экологи /БНХАУ-тай хамтарсан/	1
	115	Нано шинжлэх ухаан, инженерчлэл	1
	116	Материал судлал	1
	117	Статистик /БНХАУ-тай хамтарсан/	1



	118	Статистик	1
	119	Инженерийн бэлтгэл /Герман/	1
	120	Инженерийн бэлтгэл	1
8	121	Сэргээгдэх эрчим хүч	1
	122	Сэргээгдэх эрчим хүч /БНХАУ-тай хамтарсан/	1
	123	Дулааны цахилгаан станц	1
	124	Үйлдвэр, хотын дулаан хангамж	1
	125	Дулааны процессын автоматжуулалт	1
	126	Дулааны инженер /БНХАУ-тай хамтарсан/	1
	127	Хөргөлтийн технологи ба кондиционерийн систем	1
	128	Цахилгаан систем	1
	129	Цахилгаан системийн автоматжуулалт	1
	130	Цахилгаан электроник	1
	131	Цахилгаан хангамж	1
	132	Цахилгаан хангамж /БНХАУ-тай хамтарсан/	1
	133	Эмнэлэгийн тоног төхөөрөмж	1
	134	Био-инженерчлэл /БНХАУ-тай хамтарсан/	1
	135	Эрчим хүчиний менежмент	2
	136	Экологийн инженер /Үйлдвэрийн экологи/	1
9	137	Техник, технологийн орчуулга /Англи хэл/	5
	138	Техник, технологийн орчуулга /Орос хэл/	5
	139	Техник, технологийн орчуулга /Хятад хэл/	5
	140	Техник, технологийн орчуулга /Солонгос хэл/	5
	141	Техник, технологийн орчуулга /Япон хэл/	5
	142	Инженерийн бэлтгэл /Япон/	1



ХАВСРАЛТ 3. МЭРГЭЖИЛ

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

№	Мэргэжил	Бүлэг
1	Програм хангамж	1
2	Усан хангамж, ус цэвэрлэгээ	1
3	Халаалт, агаар сэлгэлт	1
4	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи	1
5	Иргэний ба үйлдвэрийн барилга	1
6	Машин үйлдвэрлэлийн технологи	1
7	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	1
8	Цахилгаан систем	1
9	Цахилгаан системийн автоматжуулалт	1
10	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт	1
11	Үйлдвэрлэлийн механикуулалт	1
12	Уул уурхайн машин тоног төхөөрөмж	1
13	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	1
14	Хүнс үйлдвэрлэлийн технологи	1
15	Дулааны цахилгаан станц	1
16	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	1
17	Уул уурхайн ашиглалтын технологи	1
18	Барилгын менежмент	2
19	Уул уурхайн менежмент	2
20	Эрчим хүчний менежмент	2
21	Төмөрлөгийн үйлдвэрлэлийн технологи	1
22	Санхүүгийн менежмент	1
23	Хүнсний чанар аюулгүй байдал	1

“ЭРДЭНЭТ ЦОГЦОЛБОР” ДЭЭД СУРГУУЛЬ

№	Мэргэжил	Бүлэг
1	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	1
2	Цахилгаан системийн автоматжуулалт	1
3	Автомашины ашиглалт, авто аж ахуй	1
4	Хүдрийн металлургийн технологи	1
5	Уул уурхайн машин, тоног төхөөрөмж	1
6	Уул уурхайн ашиглалтын технологи	1
7	Ашигт малтмалын баяжуулалтын технологи	1
8	Мэдээллийн технологи	1
9	Барилгын инженер /1+3/	1
10	Хүрээлэн буй орчны инженер /1+3/	1
12	Инженерийн бэлтгэл	1



Дэлгэрэнгүй мэдээллийг доорхи хаягаар холбогдон авна уу.

ШУТИС-ийн Улаанбаатар хот дахь Элсэлтийн комиссын хаяг:

Харилцах утас :	11-324319
	324590-1021, 324590-1022,
Факс:	976-11-318152
e-mail:	batdorjd@must.edu.mn
Веб хаяг:	http://www.must.edu.mn , http://www.elselt.edu.mn ,
Шуудангийн хаяг:	ш/х-520, Улаанбаатар-46, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Элсэлтийн комисс
Байрлал:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-8 Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, Хичээлийн 1-р байр 212, 213, 217 тоот өрөө Хичээлийн 2-р байр, 2-19 тоот өрөө

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

Захирал:	Доктор (Ph.D), дэд профессор Ц.Батбаатар
Утас:	70374455, 70374735
e-mail:	Batbaatarc@yahoo.com
Факс:	976-37-24455
Сургуулийн байршил, хаяг: Дархан сум. 15 дугаар баг (Шинэ Дархан).	

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ

Захирал:	Доктор (Ph.D), Д.Зоригтхүү
Утас:	976-035-73421
e-mail:	bayardulamb@yahoo.com
Факс:	976-035-73421
Сургуулийн байршил, хаяг: баян-өндөр сум. Эрдэнэт хот.	